


БАТЛАВ:
 НИЙСЛЭЛИЙН ШИНЖЛЭХ УХААН,
 ҮЙЛДВЭРЛЭЛ, ИННОВАЦЫН ГАЗРЫН
 ДАРГА  **Б.МӨНХ-ОРГИЛ**

**“10 000 ПРОГРАММИСТ” ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
 СУРГУУЛИЙН МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН 20 БАГШИЙГ СУРГАГЧААР БЭЛТГЭХ,
 ХӨГЖҮҮЛЭХ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР**

2020 оны 05-р сарын 08-ны өдөр

Дугаар-

Улаанбаатар хот

1	Захиалагч байгууллага	Нийслэлийн Шинжлэх ухаан, Үйлдвэрлэл, Инновацын газар
2	Сургалт зохион байгуулах эрх зүйн үндэслэл	<ul style="list-style-type: none"> - Монгол улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр /5.1.17 дахь заалт/ - Нийслэлийн эдийн засаг нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл /1-7 заалт/ - Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр /5.2.6 заалт/ - НИТХ-ын Тэргүүлэгчдийн 189 дүгээр тогтоол - Нийслэлийн засаг даргын 2020 оны А/214 тоот захирамж
3	Сургалтын зорилго	- Монгол Улсын Мэдээлэл технологийн салбарын өрсөлдөх чадварыг дэлхийн түвшинд дээшлүүлэх, салбарын боловсон хүчний нөөцийг бэхжүүлэх ажилгүйдлийг бууруулахад чиглэсэн “10 000 програмист” төслийн хүрээнд код бичих ур чадварыг хүүхэд, залуучуудад олгоход оршино.
4	Үргэлжлэх хугацаа	<ul style="list-style-type: none"> - Эхлэх хугацаа: 2020 оны 08 дугаар сарын 31 - Дуусах хугацаа: 2020 10 дугаар сарын 30
5	Байршил	- Улаанбаатар инновацын төв, Улаанбаатар хот, Монгол Улс
6	Гүйцэтгэх ажлын даалгавар	<ul style="list-style-type: none"> - Алгоритм, Блок шем үндэс, загварчлалын иж бүрэн сургалтыг хүргэх - Java script програмчлалын анхан шатны сургалтыг онол, дадлагын хүрээнд зохион байгуулах - Java script програмчлалын ахисан шатны сургалтыг онол, дадлагын хүрээнд зохион байгуулах - Java script програмчлалын хэл дээр суурилсан бие даасан төсөл хэрэгжүүлэх, зөвлөгөө өгч иж бүрэн Апп эсвэл вебсайт хөгжүүлнэ - Phyton програмчлалын анхан шатны сургалтыг онол, дадлагын хүрээнд зохион байгуулах - Phyton програмчлалын дунд шатны сургалтыг онол, дадлагын хүрээнд зохион байгуулах - Phyton програмчлалын хэл дээр суурилсан бие даасан төсөл хэрэгжүүлэх, зөвлөгөө өгч иж бүрэн Апп эсвэл вебсайт хөгжүүлнэ - Багаар ажиллах ур чадвар олгох зөөлөн ур чадварыг эзэмшүүлж, дадлага хийх - Асуудлын шийдвэрлэх ур чадвар олгох зөөлөн ур чадварыг эзэмшүүлж, дадлага хийх - Дизайн сэтгэлгээний сургалтыг онол, дадлагын хүрээнд

		зохион байгуулах, эзэмшүүлэх
7	Хүлээгдэж буй үр дүн	<ul style="list-style-type: none"> - Нийт 20 сургагч багшийг бэлтгэж, баталгаажуулсан байна. - Сургагч багш нар бие даан програм хангамжийн төсөл зохион байгуулах, хэрэгжүүлэх чадвартай байна. - ЕБС-ын мэдээлэл технологийн бусад багш нартаа мэргэжлийн сургалт хийж, зөвлөгөө өгөх чадартай байна. - Сурагч нартай хамтарсан баг зохион байгуулж, удирдан иж бүрэн төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх боломжтой байна. - Мэргэжлийн ур чадварыг эзэмшиж, сургалт хийх чадвартай байна. - Зөөлөн ур чадварыг эзэмшсэн бусдад хүргэх, бусдыг сургах чадвар эзэмшсэн байна. - Сургагч багш нь ЕБС-ын бусад багш нараа сургах, чадавхжуулах төсөл хэрэгжүүлэхэд шаардлагатай мэргэжлийн болон зөөлөн ур чадваруудыг эзэмшсэн байна.
8	Онцгой нөхцөл	<ul style="list-style-type: none"> - Ажлын ерөнхий зорилго болон хүрээг өөрчлөхгүйгээр харилцан зөвшилцсөний үндсэн дээр энэхүү ажлын даалгаварт өөрчлөлт оруулж болно.